



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 09 сарын 19 өдөр

Дугаар 369

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.4, 6.2.5, 6.4.4, 6.4.5, 6.4.6, 8 заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт, хэмжил зүйн газрын харьяа Ховд аймгийн аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2,300,000 (хоёр сая гурван зуун) төгрөгийн балансын үнэ, 613,333.33 (зургаан зуун арван гурван мянга гурван зуун гучин гурван мянга гучин гурван мөнгө) төгрөгийн бүхий хуримтлагдсан элэгдэлтэй хавсралтад заасан барилга, байгууламж нь Ховд аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2012 оны 48/14/25 тоот дүгнэлтээр зориулалтаар ашиглах боломжгүй нь тогтоогдсон тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Стандарт, хэмжил зүйн газрын тамгын дарга Б.Эрдэнэзул, Ховд аймгийн Стандарт, хэмжил зүйн хэлтсийн дарга Б.Эрдэнэцэцэг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, буулгах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Үл хөдлөх хөрөнгийг акталж, чөлөөлсөн газрыг байгууллагын хэрэгцээнд зориулалтын дагуу нөхөн сэргээж ашиглах;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ


А.АРИУНБОЛД

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЭРДЭНЭБЯАР

0000701

Төрийн өмчийн бодлого-зөхицуулалтын газрын
 2019 оны 09 дүгээр сарын 19 ны өдрийн
 369 дугаар тогтоолыг хавсралт



ХОВД АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТЭЛТЭЙ,
 АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ БАРИЛГА

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байрлал	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ (тегрөг)	Хуримтлагдсан элэгдэл (тегрөг)	Үлдэгдэл өртөг (тегрөг)
1	Лабораторийн барилга	2003.01.01	1 ш	2,300,000.00	613,333.33	1,686,666.67
Нийт дүн						
				(хоёр сая гурван зуун мянган)	(зургаан зуун арван гурван мянга гурван зуун гучин гурван тегрөг гучин гурван мөнгө)	(нэг сая зургаан зуун наян зургаан мянга зургаан зуун жаран зургаан тегрөг жаран долоон мөнгө)